



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/333

Булган сум

**Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл"
цогцолбор тэмцээнд оролцуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 5.2 дахь заалт, Батлан хамгаалах сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/150 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд Булган аймгийн Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулиудын ахлах ангийн сурагчдаас бүрдсэн баг тамирчдыг оролцуулсугай.

2. Тэмцээнд шаардагдах 5,331,200 (таван сая гурван зуун гучин нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй

3. Баг тамирчдыг бэлтгэн амжилттай оролцуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Т.Нямхүү), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (С.Оюунзаяа)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 20-ны ний өдрийн
А/333 дугаар захирамжийн хавсралт

ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	2	3	4
1	Унаа ачаа, тээврийн зардал	1,600,200	Пургон авто машин-2 *635л *2520 төг = 1,600,200
2	Хоол	1,800,000	15 хүн *30000* 4 өдөр =1,800,000
3	Жолоочийн цалин	160000	2 жолооч* 80000=160000
4	Жигдрэлтийн хувцас (өмд китель, гутал)	1,300,000	13 хүн* 100,000=1,300,000
5	Пудволка, малгай	195000	13 хүн *7000 *8000=195000
6	8 см голчтой Булган аймгийн логотой ялгах энгэрийн тэмдэг 1,8:0,8 харьцаатай фотостенд самбар Зэвсэгт хүчин эмблем 40*40 Булган аймгийн логотой дарцаг Сурагчдын нэр оёулах Сурагчдад үнэмлэх хийлгэх	276000	Булган логотой ялгах энгэрийн тэмдэг 13*3000=39000 фотостенд самбар-1ш 80000 Зэвсэгт хүчин 13*3500=45500 Сурагчдын нэр 13*3500=45500 40*40 дарцаг 1*40000=40000 Үнэмлэх 13*2000=26000
Нийт дүн			5,331,200